



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 6.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 593 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сайнсбагаж” ХХК-ийн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Сайнсбагаж” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 2 өдрийн дотор мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000556